



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дашбалбар сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/3/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Б.Одхүү

Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын гэрчилгээ	4
2. Аудитын тайлан	6
2.1. Оршил	6
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	8
2.8.1 Мөнгөн хөрөнгө	8
2.8.2 Авлага	9
2.8.3 Бараа материал	9
2.8.4 Үндсэн хөрөнгө	9
2.8.5 Засгийн газрын хувь оролцоо	10
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
2.11. Шилэн дансны мэдээлэл	12
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3. Менежментийн захидал	13
3.1 засаг даргын нөөцийн хөрөнгөтэй холбоотой асуудал	13
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	15
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	21
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
СХС	Сум хөгжлийн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ДОА	Дорнод аймаг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



1. Аудитын гэрчилгээ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
З/ТТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.03.25 № 334

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дашбалбар сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дашбалбар сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дашбалбар сумын төсвийн гүйцэтгэлийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520268

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дашбалбар сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Баттулга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтай холбоотой зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Дашбалбар сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дашбалбар сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 15-аас 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одхүү хариуцаж гүйцэтгэв.

Дашбалбар сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/133 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дашбалбар сумын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журамд өөрчлөлт гараагүй байна.

Дашбалбар сумын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2019 онд Дашбалбар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дашбалбар сумын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 14 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг нийт зардлын 2,503.5 сая төгрөгийн 2 хувь буюу 50.0 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 77.0 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны гүйцэтгэлийн зардал өссөнтэй холбоотой болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 5 төсвийн байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 2 тусгай сангийн, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн нь бүгд аудитад хамрагдсан.



Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 5 байгууллага нь “Зөрчилгүй” дүгнэлт өгч, 3 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгаж, илэрсэн асуудлыг нэгтгэсэн тайланд тусгалаа.

Дашбалбар сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 12,171.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс, сум хөгжлийн сангийн зээлийн хүүгийн авлагыг бүртгэхдээ хүү алдангийн орлогын 8,381.6 мянган төгрөгийг тусгаагүй алдааг аудитын явцад залруулж, 959.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 2,829.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн үзүүлэлт байхгүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

ИТХ нь нийт худалдан авалтын 31.5 хувь буюу 959.8 мянган төгрөгийн е-баримтыг анхан шатны баримт болгон хавсаргаагүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 6.5 дахь заалт “Төлбөрийн баримт нь бараа, ажил үйлчилгээний төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 1,160,6 мянган төгрөгийн залруулга хийлээ. Үүнд:

- *Дашбалбар сумын Засаг даргын тамгын газар:* Тайлант онд шүүхийн шийдвэрээр эргэж ажилдаа орсон хүний ажилгүй байсан хугацааны цалин 1,160,6 мянган төгрөгийг төсвөөс олгож, гэм буруутай этгээдээр буцаан төлүүлэх авлагыг бүртгээгүй, буруутай этгээдээс нэхэмжлээгүй байсныг авлагаар тусгуулж санхүүгийн тайланд залруулсан.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 218.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 564.3 сая төгрөг болж, 346.3 сая төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
<u>Банканд байгаа бэлэн мөнгө</u>	218.0	564.3	346.3	
Дүн	218.0	564.3	346.3	

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд нийт 564.3 сая төгрөг байгаагаас төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 556.0 сая төгрөг, арилжааны банкны дансанд 8.3 сая төгрөг байршиж байна.

2.8.2 Авлага

Авлага ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансны эхний үлдэгдэл 230.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 209.9 сая төгрөг болж, 20.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.2	0	-0.2
Зээлийн авлага	229.9	209.9	-20
Дүн	230.1	209.9	-20.2

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 38.6 сая төгрөгийн дараах авлага байна.
Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн 1 жилийн насжилттай 113.9 сая төгрөгийн авлага
 - Сум хөгжүүлэх сангийн 3-4 жилийн насжилттай 57.4 сая төгрөгийн авлага
- Сум хөгжүүлэх сангийн 5-аас дээш насжилттай шүүхийн шийдвэрээр төлүүлэхээр гарсан 38.6 сая төгрөгийн авлага байна. Энэ нь найдваргүй авлага үүсэх үр дагавартай байна.

Хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүү болон алдангид сумаас мэдэгдэх хуудас өгөх, шүүхэд шилжүүлэх зэрэг арга хэмжээг авч ажилласан байна.

Зээлийн төлбөрөө хугацаандаа төлөөгүй улмаас дараа дараагийн зээл олголтод сөрөг үр дагавартай байна.

2.8.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ эхний үлдэгдэл 413.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 440.5 сая төгрөг болж, 27.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	2.3	6.6	+4.3
Бичиг хэрэг материал	0.5	1.3	+0.8
Аж ахуйн материал	248.3	257.1	+8.8
Сэлбэг хэрэгсэл	3.5	3.2	-0.3
Түлш, шатах тослох материал	1.8	1.0	-0.8
Барилгын засварын материал	0	1.4	+1.4
Бусад хангамжийн материал	4.0	11.2	+7.2
Мал амьтад	153.0	158.7	+5.7
Дүн	413.4	440.5	+27.1

Мөн ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа материал байхгүй байна.

2.8.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ эхний үлдэгдэл 6,003.7



сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7,267.7 сая төгрөг болж, 1,264.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж	3,926.60	4,477.70	551.1
Авто-тээврийн хэрэгсэл	246.6	307.6	61.0
Машин, тоног төхөөрөмж	492.9	514.7	21.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	183.8	183.8	0
Зам гүүрийн байгууламж	806.1	947.3	141.2
Түүх соёл, музейн дурсгалт зүйл	1.1	1.1	0
Бусад үндсэн хөрөнгө	170.6	329.1	158.4
Дуусаагүй барилга байгууламж	24.2	353.2	329
Ном	27.1	27.5	0.4
Программ хангамж	3.4	4.3	0.9
Бусад биет бус хөрөнгө	121.3	121.3	0
Дүн	6,003.7	7,267.7	1,264.0

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,308.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн бөгөөд балансаас балансад 292.3 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан, 1,015.9 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй авсан дүнгээр тус тус нэмэгдэж, 20.1 сая төгрөгийн хөрөнгө акталсан дүнгээр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд 2019-2020 оныг дамжин хийгдэж байгаа 353.2 сая төгрөгийн хүүхдийн цэцэрлэгийн дуусаагүй барилга бүртгэлтэй байна.

2.8.5 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,832.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7,082.2 сая төгрөг болж өссөн нь хөрөнгө оруулалттай холбоотой байна.

Хүснэгт № 31. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт/+, бууралт /-/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
<u>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</u>	1,606.0	1,606.0	0	0
<u>Хуримтлагдсан үр дүн</u>	2,826.5	4,076.2	1,249.7	0
<u>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</u>	1,400.0	1,400.0	0	0
<u>Бодлогын өөрчлөлт алдааны залруулга</u>	0	0	0	0
Дүн	5,832.5	7,082.2	1,249.7	0

Засгийн газрын оруулсан капитал болон хөрөнгийн дахин үнэлгээний үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



Дашбалбар сумын ИТХ-ын “2019 оны орон нутгийн төсөв батлах тухай” тогтоолд зааснаар тайлант онд 302.1 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 650.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 215.4 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Хувиараа ААЭОАТатвар	2.0	2.2	0.2	1.1
Суутгагч 10 хувь	54.0	49.6	-4.4	0.9
Галт зэвсэг АТ	4.3	4.1	-0.2	1.0
Тэмдэгтийн хураамж	5.0	5.0	0.0	1.0
Усны төлбөр	42.7	42.7	0.0	1.0
Агнуурын нөөц АТ	12.8	19.6	6.8	1.5
Түгээмэл тархацтай АМНАТ	10.0	2.1	-7.9	0.2
Хадгаламжийн хүү	27.5	29.6	2.1	1.1
Хүү торгууль	10.0	10.8	0.8	1.1
Бусад	123.5	114.5	-9.0	0.9
Газрын дуудлага худалдааны орлого	10.3	370.7	360.4	36.0
Нийт дүн	302.1	650.9	348.8	215.4

Нийт орлого 384.8 сая төгрөгөөр давсан нь газрын дуудлага худалдааны орлого давж биелсэнтэй холбоотой байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,804,6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,875.8 сая төгрөгийг урсгал зардалд, 928.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардал 2,804.6 сая төгрөг бөгөөд улсын төсвөөс 1,126.9 сая, орон нутгийн төсвөөс 854.2 сая, ОНХС-гаас 615.9 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 1.0 сая, урьд оны үлдэгдлээс 71,1 сая, зээлийн эргэн төлөлтөөс 85.5 сая, хандив тусламжаас 50,0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,126.9 сая, орон нутгийн төсвөөс 854.2 сая, ОНХС-гаас 615.9 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 1.0 сая, урьд оны үлдэгдлээс 71,1 сая, зээлийн эргэн төлөлтөөс 125.9 сая, хандив тусламжаас 14,0 сая төгрөгийн санхүүжилтийг авсан бөгөөд хандив тусламж 36.0 сая төгрөгөөр дутуу орсон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,621.0 сая төгрөг буюу 93,4 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажилласан, төсвийн хөрөнгө оруулалтуудын ажлууд хийгдээгүйгээс шалтгаалсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 928.8 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 841.1 сая төгрөгийг зарцуулж, 87.7 сая төгрөгийн төсөл арга хэмжээ хийгдээгүй байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 29.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 19.3 сая төгрөг, нийт 48.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс хангамж бараа материалын зардалд 5.1 сая төгрөг, бусад хөрөнгийн зардалд 28.8 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 7.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 5.1 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1.0 сая төгрөг, урамшууллын зардал 0.4 сая төгрөг, томилолт 0.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.



2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Сумдын Засаг дарга нар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс, журамд зөвшөөрөгдөөгүй арга хэмжээнд зарцуулахаар захирамж гаргаж байгааг анхаарах шаардлагатай.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дашбалбар сум нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 124 мэдээллийг хугацаанд нь, 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 43.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 06 сарын 14 өдрийн 01/204 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дашбалбар сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дашбалбар сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦИЙН ХӨРӨНГӨТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгөөс мөрийн хөтөлбөрт тусгагдсан гэсэн үндэслэлээр нийт 2,829.9 мянган төгрөгийг журамд заагдаагүй арга хэмжээнд зарцуулсан байна.

3.1.2 Эрсдэл: Хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах

3.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтыг мөрдөн ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	861 665 497,31	1 214 792 615,31
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	218 049 337,48	564 328 520,97
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	218 049 337,48	564 328 520,97
3121	Төгрөг	218 049 337,48	564 328 520,97
31211	Төрийн сангийн харилцах	217 864 338,81	555 983 463,95
31213	Арилжааны банк дахь харилцах	184 998,67	8 345 057,02
33	АВЛАГА	230 136 294,00	209 895 279,00
33400	Зээлийн хүүгийн авлага		8 183 621,00
335	Бусад авлага	229 886 091,00	201 711 658,00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	229 886 091,00	201 711 658,00
35	БАРАА МАТЕРИАЛ	413 479 865,83	440 568 815,34
351	Түүхий эд материал	2 299 783,11	6 597 983,11
35110	Тусгай зориулалттай материал	2 299 783,11	6 597 983,11
354	Хангамжийн материал	258 197 816,72	275 233 566,23
35410	Бичиг хэргийн материал	539 315,00	1 328 740,00
35420	Аж ахуйн материал	248 315 473,72	257 094 018,03
35430	Сэлбэг хэрэгсэл	3 549 940,00	3 240 940,00
35440	Түлш, шатах тослох материал	1 793 090,00	961 560,20
35450	Барилгын засварын материал	-	1 372 000,00
35470	Бусад хангамжийн материал	3 999 998,00	11 236 308,00
35600	Мал амьтад	152 982 266,00	158 737 266,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4 970 881 338,15	5 867 424 990,38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4 970 881 338,15	5 867 424 990,38
392	Биет хөрөнгө	4 847 572 171,08	5 743 853 843,53
39201	Барилга, байгууламж, орон сууц	3 926 570 456,46	4 477 681 920,46
39202	Хуримтлагдсан элэгдэл	(77 822 392,69)	(288 866 114,09)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	246 637 285,00	307 637 285,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(141 168 038,82)	(170 418 435,62)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	492 865 174,20	514 741 177,20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(376 284 097,21)	(408 402 177,80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	183 831 588,70	183 786 588,70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(111 442 819,81)	(125 595 112,59)
39209	Зам, гүүрийн байгууламж	806 137 429,99	947 312 653,99
39210	Хуримтлагдсан элэгдэл	(276 255 821,23)	(348 599 928,81)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1 050 626,00	1 050 626,00
39214	Бусад үндсэн хөрөнгө	170 641 753,00	329 100 223,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(48 498 090,51)	(56 261 247,91)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	24 190 532,00	353 209 600,00
39217	Ном	27 118 586,00	27 476 786,00
393	Биет бус хөрөнгө	123 309 167,07	123 571 146,85
39301	Програм хангамж	3 435 000,00	4 367 200,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1 443 832,93)	(2 114 053,15)
39303	Бусад биет бус хөрөнгө	121 318 000,00	121 318 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5 832 546 835,46	7 082 217 605,69
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5 832 546 835,46	7 082 217 605,69
51	Засгийн газрын хувь оролцоо	5 832 546 835,46	7 082 217 605,69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1 605 979 959,26	1 605 979 959,26
512	Хуримтлагдсан үр дүн	2 826 538 109,05	4 076 208 879,28
51210	Өмнөх үеийн үр дүн	3 039 605 719,05	2 826 538 109,05
51220	Тайлант үеийн үр дүн	(213 067 610,00)	1 249 670 770,23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1 400 028 767,15	1 400 028 767,15



Дашбалбар сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5 832 546 835,46	7 082 217 605,69
---	--	------------------	------------------

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2 657 291 259,07	5 100 060 586,65
11	ТАТВАРЫН ОРЛОГО	134 142 826,44	496 119 116,12
110	Орлогын албан татвар	24 084 527,44	51 873 952,12
1100	Хувь хүний орлогын албан татвар	24 084 527,44	51 873 952,12
110002	Үйл ажиллагааны орлого	3 154 200,00	2 227 000,00
110008	Шууд бус орлого	20 930 327,44	49 646 952,12
113	Хөрөнгийн албан татвар	4 560 000,00	4 095 000,00
113002	Бууны албан татвар	4 560 000,00	4 095 000,00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	105 498 299,00	440 150 164,00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6 425 840,00	7 143 164,00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	4 824 840,00	5 011 164,00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	100 000,00	2 132 000,00
1181	Газрын төлбөр	40 161 459,00	370 670 000,00
118102	Дуудлага худалдаа	40 161 459,00	370 670 000,00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	58 911 000,00	62 337 000,00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	19 200 000,00	19 600 000,00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	39 711 000,00	42 737 000,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	437 343 062,07	1 785 879 672,27
120	Нийтлэг татварын бус орлого	437 343 062,07	1 446 879 672,27
120002	Хүүгийн орлого	24 546 964,07	29 550 273,06
120003	Торгуулийн орлого	14 790 000,00	10 795 758,70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	201 640 098,00	1 043 820 846,51
